

Огноо: 2026.03.05

№ 20

Улаанбаатар хот

**Олон улсын зах зээлд бонд нэмж гаргах тухай**

Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 41.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.6, 83 дугаар зүйлийн 83.8 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Төрийн банк" ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.13.9, 10.13.31 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 73 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Олон улсын зах зээлд гаргасан 8.9 хувийн купонтой, 200.0 сая ам.долларын хэмжээтэй бонд дээр нэмж 100.0 сая ам.долларын бондыг тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн дагуу, олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан, банкны тогтвортой үйл ажиллагаанд сөрөг нөлөө, эрсдэл учруулахгүйгээр гаргах эрхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д олгосугай.

2. Олон улсын зах зээлд нэмж бонд гаргахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдүүдийг сонгож, хамтран ажиллах гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Б.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Г.ЗОЛБОО